

## НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлд Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот байхаар тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн батлах үндэслэл болно. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтэд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдох арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурал 1994 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль нь нийслэлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулж ирсэн бөгөөд нэг удаа уг хуульд өөрчлөлт орсон байна.

Нийслэлийн эрх зүйн байдал, удирдлагын тогтолцоо, бүрэн эрх, чиг үүргийг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиас гадна Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад 150 гаруй хуулиар зохицуулж байна. Монгол Улсын нийслэлийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа онцлог нэгж болох Улаанбаатар хотод үйлчлэх эдгээр хууль тогтоомж нь өөр хоорондоо уялдаа мутай, зарим зохицуулалтууд нь давхардсан зэрэг зөрчил бий болсон, нийслэл хот цаашид ямар загвараар хөгжих, онцлог нь юу болох, ямар чиг үүрэг гүйцэтгэх, төр засагтай хэрхэн, ямар хэмжээнд харилцах, бусад орны жишгийг судалж, нэвтрүүлэх талаар олон судалгаа, практик ажилтнуудын санал зөвлөмж гарсаар байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан танилцуулж байна.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Нийтлэг үндэслэл, Нийслэл хот, түүний чиг үүрэг, Нийслэл хотын эдийн засгийн харилцаа, Нийслэл хотын удирдлага, түүний бүрэн эрх, Нийслэл хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах харилцаа, Нийслэл хотын дагуул хот, хаяа тосгон, Бусад гэсэн 7 бүлэг, 46 зүйлээс бүрдэх бөгөөд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан.

1/ Хуулиар зохицуулагдах эхний бүлэг харилцаа нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн үйлчлэх хүрээ, нийслэл хотын зохион байгуулалтын үндэс, нийслэл хотыг хөгжүүлэх бодлого, нийслэл хотын онцлогтой холбоотой харилцаа бөгөөд одоогийн хүчин төгөлдөр хуулиар тодорхойлсон хуулийн зорилт, зохицуулах харилцааг өргөтгэж, нийслэл хотын эдэлбэр газар, бүсчлэлтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулахаар тусгасан.

2/ Нийслэл хот, түүний чиг үүргийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын төрийн дээд байгууллага

байнга оршдог нийслэл Улаанбаатар хотын хувьд хэрэгжүүлэх тусгай чиг үүргийг тодорхойлж, төрийн дээд байгууллагатай харилцах эрх зүйн үндсийг тусгахыг зорьсон.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаас бусад чиг үүргийг энэ бүлэгт тодорхойллоо.

3/ *Нийслэл хотын эдийн засгийн харилцаа гэсэн бүлэгт Нийслэл нь нийслэл хотын тусгай болон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгмийн асуудлаа бие даан шийдвэрлэх бодит чадвартай байх үндсийг тусгасан.*

Энэ хүрээнд иргэн, хуулийн этгээд нь нийслэл хотоос үйлчилгээ хүртэж холбогдох татвар, хураамж, төлбөр төлөх, хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийслэл өөрийн хөрөнгөд үндэслэн үнэт цаас гаргах, төсвийн орлого болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалтыг тусгаж, концесс, нийслэлийн сан, чөлөөт бүсийн талаар энэ хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулахаар тусгасан.

4/ *Нийслэл хотын удирдлага, түүний бүрэн эрх гэсэн бүлэгт нийслэлийн удирдлагын одоогийн тогтолцоог хэвээр хадгалахын зэрэгцээ Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн онцлог бүрэн эрхийг тодорхойлсон. Мөн Захирагааны ерөнхий хуульд нийцүүлэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч зарим бүрэн эрхээ хотын Ерөнхий менежерт шилжүүлэх боломжийг бий болгосон.*

5/ *Нийслэл хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах харилцааны хүрээнд нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ нийслэлийн удирдлагын зүгээс төрийн дээд, төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хот, дүүргийн удирдлага, иргэн, аж ахуйн нэгжтэй харилцах харилцааны онцлогийг тусгасан.*

6/ Нийслэл хотын дагуул хот, хаяа тосгон нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулах онцлог харилцаа юм. Хэдийгээр одоогийн хуулиудаар энэ асуудал хөндөгдсөн боловч, дагуул хот, хаяа тосгон, түүнтэй холбоотой бусад харилцааг хуулиар нарийвчлан зохицуулаагүй явж ирсэн тул энэ бүлэгт дагуул хот, хаяа тосгон, түүний удирдлага, зохион байгуулалтын онцлог, бусад харилцааны эрх зүйн үндсийг тусгасан.

7/ *Бусад гэсэн бүлэгт нийслэл хотын гадаад хамтын ажиллагаа, нийслэлийн өдөр, шагнал, нийслэл хотын судалгааны байгууллагын талаар тусгалaa.*

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тухай, Өрийн удирдлагын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг бусад дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан.

-ооОо-

**НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах дараахь хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн”. 2 дахь хэсэгт “Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурал Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг 1994 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан ба үүнээс хойш 26 жил нийслэлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг уг хуулиар зохицуулж байна.

Эдүгээ Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиас гадна Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад 150 гаруй хуулиар нийслэлийн эрх зүйн байдал, нийслэл, дүүрэг, хорооны иргэдийн Хурал, Засаг даргын эрх хэмжээ, бүрэн эрхийг тодорхойлж байна.

Мөн Улаанбаатар хотын үйл ажиллагаатай холбоотой зарим асуудалд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн зүйл, заалтыг хэрэглэж байна.

Монгол Улсын нийслэлийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа онцлог нэгж болох Улаанбаатар хотод үйлчлэх эдгээр хууль тогтоомж нь өөр хоорондоо уялдаа муутай, зарим зохицуулалтууд нь давхардсан зэрэг зөрчил бий болжээ.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдуугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана гэж заасан боловч Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад салбар хуулиудад эдгээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн онцлогт нь тохирсон эрх зүйн зохицуулалт, чиг үүргийг нь тодорхойлохгүйгээр аймгийг нийслэлтэй, сумыг дүүрэгтэй “адилтгах” байдлаар удирдлагын бүрэн эрхийг тодорхойлж, нийслэл хотын эдийн засаг, нийгмийн амьдралын онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалтгүйгээр явж иржээ.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлах үеийн үзэл баримтлал, хэлэлцүүлгээс үзэхэд тухайн үед нийслэл хот цаашид ямар загвараар хөгжих, төр засагтай хэрхэн, ямар хэмжээнд харилцах, бусад орны жишиг ямар байгааг хөндсөн байдаг. Гэвч хуулиар зохицуулахдаа дээр дурдсан асуудлуудыг нэг мөр шийдвэрлээгүй, нийслэлийн удирдлагаас төрийн дээд болон төв байгууллагатай хэрхэн харилцах зарчим, эрх зүйн зохицуулалт сул болсноос тэдгээрийн эрх хэмжээ, бүрэн эрх давхцах, хийдэл үүсэх зэрэг нөхцөл байдал ажиглагдах болсон байна. Тухайлбал, Нийслэл хотын хувьд төрийн захиргааны төв байгууллага нь бодлого, төлөвлөлтийн ямар чиг үүргийг

хэрэгжүүлэх, нийслэлийн удирдлага ямар асуудлыг хариуцан шийдвэрлэх талаар салбар хуулиудаар зөрүүтэй байдлаар зохицуулагдаж байна.

Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан нийслэлийн оршин суугчийн “эрүүл аюулгүй орчинд амьдрах” эрхийн баталгааг хангах нь нийслэл хотын удирдлагын үүрэг боловч нийслэл хот нь нийгэм, эдийн засаг, санхүүгийн асуудлаа бие даан шийдвэрлэх эрх зүйн боломж зарим талаар хязгаарлагдмал байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль зэрэг салбар хуулиудаар илэрхийлэгдэх байгаа бөгөөд нийслэл нь эдийн засаг, санхүүгийн хувьд харьцангуй бие даан, оршин суугчдынхаа өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

Иймд эдгээр нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн боловсруулж батлах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна гэж хууль санаачлагчийн хувьд үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэснийг баримталсны сацуугаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” гэсэн заалтыг иш үндэс болголоо.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн заалтыг мөн харгалzan үзлээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Улаанбаатар ба дагуул хотуудыг хөгжүүлэх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасныг үндэс болголоо.

Мөн 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын нийслэл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болохтой холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна”, 9 дүгээр зүйлийн 9.2-т “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлыг хуулиар тогтооно” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 24.1-т зааснаас бусад Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын чиг үүргийг хуулиар тогтооно” гэж заасныг тус тус удирдлага болголоо.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн бүтэц, зүйл, заалтын 50-аас дээш хувьд нь өөрчлөлт орж байгааг харгалzan Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Нийслэлийн эрх

зүйн байдлын тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн зорилт нь нийслэл хотын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, үйл ажиллагааны зарчим, удирдлагын эрх хэмжээ, нийслэл хотын удирдлагаас төрийн дээд, төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон бусад этгээдтэй харилцах эрх зүйн үндсийг тодорхойлоход оршино.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь Нийтлэг үндэслэл, Нийслэл хот, түүний чиг үүрэг, Нийслэл хотын эдийн засгийн харилцаа, Нийслэл хотын удирдлага, түүний бүрэн эрх, Нийслэл хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах харилцаа, Нийслэл хотын дагуул хот, хаяа тосгон, Бусад гэсэн 7 бүлгээс бүрдэнэ.

#### 1/ Нэгдүгээр бүлэг -Нийтлэг үндэслэл:

Хуулиар зохицуулагдах эхний бүлэг харилцаа нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн үйлчлэх хүрээ, нийслэл хотын зохион байгуулалтын үндэс, нийслэл хотыг хөгжүүлэх бодлого, нийслэл хотын онцлогтой холбоотой харилцаа байна.

Одоогийн хүчин төгөлдөр хуулиар тодорхойлсон хуулийн зорилт, зохицуулах харилцааг өргөтгөж, нийслэл хотын эдэлбэр газар, бусчлэлтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулна.

#### 2/ Хоёрдугаар бүлэг- Нийслэл хот, түүний чиг үүрэг:

Энэ бүлэгт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын төрийн дээд байгууллага байнга оршдог нийслэл Улаанбаатар хотын хувьд хэрэгжүүлэх тусгай чиг үүргийг тодорхойлж, төрийн дээд байгууллагатай харилцах эрх зүйн үндсийг тусгана. Энэ хүрээнд төрийн дээд, төв байгууллага, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын ажиллах хэвийн нөхцлийг хангах, үндэсний хэмжээний өв соёлыг хамгаалах болон улсын чанартай арга хэмжээний зохион байгуулалтыг хангах, олон улсын тээвэр, логистикийн үйл ажиллагааны нөхцлийг бүрдүүлэх зэрэг чиг үүргийг тодорхойлно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаас бусад чиг үүргийг тодорхойлно.

#### 3/ Гуравдугаар бүлэг- Нийслэл хотын эдийн засгийн харилцаа:

Нийслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу "эдийн засаг, нийгмийн цогцолбор"-ын хувьд, мөн нийслэл хотын тусгай болон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгмийн асуудлаа бие даан шийдвэрлэх бодит чадвартай байх үндсийг энэ бүлэгт тусгана.

Нийслэл өмчтэй байна. Нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулагдах өмчийн удирдлага, харилцааны онцлогийг энэ хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тодорхойлно.

Нийслэл, дүүргийн өмчийн харилцааг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

Түүнчлэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийслэл өөрийн хөрөнгөд үндэслэн үнэт цаас гаргах, төсвийн орлого болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалтыг тусгаж, концесс, нийслэлийн сангийн талаар зохицуулна.

Нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төсвийн хуваарилалтын зарчимд орох зохих өөрчлөлтийг Төсвийн тухай хуульд тусгана.

Иргэн, хуулийн этгээд нь нийслэл хотоос үйлчилгээ хүртэж холбогдох татвар, хураамж, төлбөр төлөх ба уг харилцааг энэ хуулиар болон татварын хууль тогтоомжоор зохицуулна.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулах онцлог харилцаа нь нийслэлийн чөлөөт бүсийн асуудал байна.

Аливаа улсын нийслэл хот нь бие даасан хот гэхээсээ илүү тухайн улсын өнгө төрх болж, гадаадын зочид, жуулчид анхлан зочлох, танилцах чухал газар болдгийнх нь хувьд түүний эдийн засгийн хөгжлийн бодлогыг тусгайлан авч үзэж, онцлог зохицуулалтын хүрээнд дэмжих олон улсын жишигийн дагуу Монгол Улсын нийслэл хотын хөгжлийг дэмжих төрийн үүргийн тухай зохицуулалт энэ хуульд шинээр орж байна.

#### 4/ Дөрөвдүгээр бүлэг-Нийслэл хотын удирдлага, түүний бүрэн эрх:

Энэ бүлэгт Нийслэлийн удирдлагын одоогийн тогтолцоог хэвээр хадгалахын зэрэгцээ Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн онцлог бүрэн эрхийг тодорхойлно.

Мөн нийслэл хотын тусгай болон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх, Улаанбаатар хотын амьдралын хүрээний асуудалтай холбоотойгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Ерөнхий менежер болон дүүргийн удирдлага хооронд үүсэх харилцааг нарийвчлан зохицуулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн зарим бүрэн эрхийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хотын Ерөнхий менежерт шилжүүлэн хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг тусгана.

#### 5/ Таевдугаар бүлэг- Нийслэл хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах харилцаа:

Энэ бүлгээр нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн дээд, төв байгууллага, засаг захирагаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хот, дүүргийн удирдлага, иргэн, аж ахуйн нэгжтэй нийслэлийн удирдлагын зүгээс харилцах харилцааг зохицуулна.

#### 6/ Зургадугаар бүлэг-Нийслэл хотын дагуул хот, хаяа тосгон:

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулах онцлог харилцаа нь нийслэл хот ба түүний дагуул хот, хаяа тосгоны асуудал байна. Хэдийгээр одоогийн хуулиудаар энэ асуудал хөндөгдсөн боловч, дагуул хот, хаяа тосгон, түүнтэй холбоотой бусад харилцааг хуулиар нарийвчлан зохицуулаагүй явж иржээ.

Иймд энэ бүлгээр Нийслэл хотын дагуул хот, хаяа тосгон, түүний удирдлага, зохион байгуулалтын онцлог, бусад харилцааг зохицуулна.

#### 7/Долоодугаар бүлэг-Бусад

Энэ бүлэгт нийслэл хотын гадаад хамтын ажиллагаа, нийслэлийн өдөр, шагнал, нийслэл хотын судалгааны байгууллагын талаар тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Энэ хуулийн төсөл батлагдсанаар нийслэл хот, түүний удирдлагын эрх зүйн орчин боловсронгуй болж, хууль хэрэглээний болоод зохион байгуулалт, удирдлагын хувьд нэг мөр, ойлгомжтой болохоос гадна Үндсэн хуулийн үзэл баримтлалтай бүрэн нийцэх бөгөөд хууль хоорондын уялдаа хангагдаж, хэрэгжилтийг нэг мөр хангах нөхцөл бүрдэнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тухай, Өрийн удирдлагын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг бусад дагалдах хуулийн төслүүдийг боловсруулна.

-ооОо-

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот /цаашид "Нийслэл хот" гэх-/ын эрх зүйн үндсийг тодорхойлоход оршино.

##### 2 дугаар зүйл. Хуулийн зохицуулах харилцаа

2.1. Энэ хуулиар Нийслэл хотын тусгай болон нийтлэг чиг үүрэг, нийслэл хотыг хөгжүүлэх бодлого, эдийн засаг, санхүүгийн болон удирдлага, зохион байгуулалтын онцлог, нийслэл хотын дагуул хот, хаяа тосгоны эрх зүйн үндэс, нийслэл хотын удирдлагаас төрийн дээд болон төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах харилцааг зохицуулна.

2.2. Нийслэл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болохтой холбоотой нийтлэг харилцааг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулна.

2.3. Нийслэл нийтийн эрх зүйн этгээдийн хувьд хувийн эрх зүйн харилцаанд оролцохтой холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

##### 3 дугаар зүйл. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

3.1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 4 дүгээр зүйл. Нийслэл хотын эрх зүйн үндэс, зохион байгуулалт

4.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь энэ хуулиар олгосон онцлог чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалттай тусгай статус бүхий хот мөн.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

4.2. Нийслэл хот нь засаг захиргааны хувьд дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна.

4.3. Нийслэл хот нь дагуул хот, хаяа тосгон, чөлөөт бүстэй байна.

### **5 дугаар зүйл. Нийслэл хотыг хөгжүүлэх бодлого**

5.1. Нийслэл хот нь нийгэм, соёлын амьдралын бүхий л хүрээнд тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлсэн, эдийн засаг, байгаль орчны зохистой тэнцлийг хангасан бодлого баримтална.

5.2. Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлтийн бодлого нь үндэсний уран барилгын өв уламжлалыг дэлхийн нийслэл хотуудын хөгжлийн нийтлэг жишигтэй хослуулан хөгжүүлэхэд үндэслэнэ.

5.3. Нийслэлийг амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй нэгдсэй стандарт бүхий ухаалаг хот болгон хөгжүүлнэ.

### **6 дугаар зүйл. Нийслэлийн нутаг дэвсгэр, эдэлбэр газар**

6.1. Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байна.

6.2. Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдож, энэ хуульд өөрөөр заагаагүй бол нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан гортиг бүхий газрыг нийслэл хотын эдэлбэр газар гэнэ.

### **7 дугаар зүйл. Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл**

7.1. Нийслэл хотын эдэлбэр газар нь бүсчлэлтэй байж болно.

7.2. Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл тогтоо шалгуур үзүүлэлтийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал оруулснаар Засгийн газар тогтооно.

7.3. Энэ зүйлийн 7.2-т заасан шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл, түүнд мөрдөх журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

### **8 дугаар зүйл. Бэлгэ тэмдэг**

8.1. Нийслэл хот бэлгэ тэмдэгтэй байж болно.

8.2. Бэлгэ тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Нийслэл хот, түүний чиг үүрэг**

### **9 дүгээр зүйл. Нийслэл хотын чиг үүрэг**

9.1. Нийслэл хот нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон энэ хуулиар олгосон тусгай болон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.2. Нийслэл хот нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1-д заасны дагуу Монгол Улсын нийслэл хотын хувьд энэ хуульд заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.3. Нийслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1-д заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан болон энэ хуульд заасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

## **10 дугаар зүйл. Нийслэл хотын тусгай чиг үүрэг**

10.1. Нийслэл хотын тусгай чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

10.1.1. төрийн дээд, төв байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах;

10.1.2. гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрын аюулгүй байдлыг хангах;

10.1.3. үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, урлаг спорта, хурал, улс төрийн арга хэмжээ;

10.1.4. олон улсын санхүү, эдийн засаг, аялал жуулчлалын төв, зорчигч болон ачаа тээвэр, логистикийн үйл ажиллагаа;

10.1.5. үндэсний хэмжээний архитектур, түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт;

10.1.6. энэ хуульд заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, барилга байгууламж, авто зам, нийтийн эзэмшилийн зам, талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн засвар, арчлалт, цэвэрлэгээ үйлчилгээ, хамгаалалт;

10.1.7. хуульд заасан бусад чиг үүрэг.

10.2. Засгийн газар энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт жил бүр тусгана.

10.3. Шаардлагатай тохиолдолд нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах өмчийг нийслэлд эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэж болно.

## **11 дүгээр зүйл. Нийслэлийн нийтлэг чиг үүрэг**

11.1. Нийслэлийн нийтлэг чиг үүрэгт Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаас гадна дараах асуудал хамаарна:

- 11.1.1. хотын хөрөнгийн сан, үйлчилгээний төлбөр, хураамж;
  - 11.1.2. нийслэлийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр, хэрэгжилт;
  - 11.1.3. хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагаа;
- Тайлбар: Хотын аж ахуй нь оршин суугчдын нийгэм, эдийн засаг, ахуй, соёлын хэрэгцээг хангахтай холбогдсон үйлдвэр, үйлчилгээний газар, орон сууц, зам, тээвэр, холбоо, дулаан, усан хангамж, цэвэрлэх байгууламж болон хот нийтийн аж ахуй зэргээс тус тус бүрдэнэ.
- 11.1.4. орчны аюулгүй байдал /амьтан тэжээх, золбин амьтан/, стандарт, тохижуулалт;
  - 11.1.5. нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, нийтлэг зохицуулалт;
  - 11.1.6. хотын орон сууцны сан, ашиглалт, хуваарилалт;
  - 11.1.7. хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа;
  - 11.1.8. нийслэлд шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт;
  - 11.1.9. нийслэлийн авто замын арчлалт, засвар, хяналт.
  - 11.1.10. хүн амын үндны болон ахуйн хэрэгцээний төвлөрсөн усан хангамж;
  - 11.1.11. хэсэгчилсэн инженерийн хангамж, ус, дулаан, цахилгаанаар хангах;
  - 11.1.12. нийтийн байрны ашиглалт, зохицуулалт;
  - 11.1.13. Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны зохицуулалт, хяналт;
  - 11.1.14. гадна зар сурталчилгааны зохицуулалт, хяналт;
  - 11.1.15. хуульд заасан бусад чиг үүрэг.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Нийслэл хотын эдийн засгийн харилцаа

#### 12 дугаар зүйл. Нийслэл хотын эдийн засгийн үндэс

12.1. Нийслэл хотын эдийн засгийн үндэс нь улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн нийслэлийн өмч, татварын болон татварын бус орлого, нийслэлийн сангийн хөрөнгөөс бүрдэнэ.

12.2. Нийслэл хотын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, бие даан хөгжих, баталгаагаар хангах нь төр, нийслэлийн үүрэг бөгөөд энэ харилцааг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

## **13 дугаар зүйл. Нийслэл хотын төсөв**

13.1. Нийслэл хот төсөвтэй байна.

13.2. Нийслэл хотын төсөв нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

13.3. Нийслэл хотын төсвийг энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна.

13.4. Нийслэлийн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсын төсвийн санхүүжилт, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бурдэнэ.

13.5. Нийслэл хотын төсвийн харилцааг энэ хуульд заасан зарчмыг баримтлан Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

## **14 дүгээр зүйл. Нийслэлийн өмч**

14.1. Нийслэл өмчтэй байна.

14.2. Нийслэлийн өмч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг болон энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хууль тогтоомжид заасны дагуу эзэмших, ашиглах, захирал зарцуулах хөрөнгө мөн.

14.3. Нийслэлийн өмчийн харилцааг хуулиар зохицуулна.

14.4. Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн өмчийн өмчлөх эрхийг нийслэлд хууль тогтоомжид заасны дагуу шилжүүлэн өгч болно.

## **15 дугаар зүйл. Нийслэл концесс, үнэт цаас гаргах**

15.1. Нийслэл нь хууль тогтоомжид заасан журмын дагуу концесс болон үнэт цаас гаргана.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасан асуудлыг Нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

15.3. Нийслэл нь төсвийн жилийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зардлынхаа 50 хувиас багагүй байх тохиолдолд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төслийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.

15.4. Энэ хуулийн 15.3-т заасны дагуу өр үүсгэх асуудлыг нийтэд мэдээлж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

15.5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч өр үүсгэх аливаа гэрээнд гарын үсэг зурсан болон үнэт цаас арилжаалснаас хойш ажлын 10 өдрийн дотор гэрээний хуулбар, холбогдох баримт бичиг, мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

## **16 дугаар зүйл. Нийслэлийн өмчит хуулийн этгээд**

16.1. Нийслэл нь өөрийн өмчийн хуулийн этгээдтэй байж болно.

16.2. Энэ хуульд заасан нийслэлийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажил, үйлчилгээг нийслэлийн өмчит хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

## **17 дугаар зүйл. Нийслэл хотын татвар**

17.1. Нийслэл хот татвартай байна. Нийслэл хотын татварыг хуулиар тогтооно.

17.2. Нийслэл нь хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд төлбөр, хураамжийн хэмжээг тогтооно.

## **18 дугаар зүйл. Нийслэлийн сан**

18.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасныг үндэслэн дор дурдсан төсвийн бус сантай байж болно:

- 18.1.1. хот байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх;
- 18.1.2. ухаалаг, цахим хотын хөгжлийг дэмжих;
- 18.1.3. үйлдвэрлэл, инновацийг дэмжих;
- 18.1.4. ногоон хөгжлийг дэмжих;
- 18.1.5. аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- 18.1.6. эрсдэлийг бууруулах;
- 18.1.7. хөрөнгө оруулалтыг дэмжих;
- 18.1.8. хотын стандарт, соёлыг хөгжүүлэх;
- 18.1.9. бусад.

18.2. Энэ хуулийн 18.1-д заасан санг дагнасан болон хамтын хэлбэрээр байгуулж болох ба түүнийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

18.3. Энэ хуулийн 18.2-т заасны дагуу тогтоосон журмыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлнэ.

## **19 дүгээр зүйл. Нийслэл хот дахь хөрөнгө оруулалт, түүний баталгаа**

19.1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.2-т заасан этгээд нь нийслэлийн өмчит ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн хөрөнгөд биет болон: биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт хийж болно.

19.2. Энэ хуулийн 19.1-д заасны дагуу ирүүлсэн хөрөнгө оруулалт хийх саналыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний эрх олгосноор нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиргач шийдвэрлэнэ.

19.3. Нийслэл хотын удирдлага нь хөрөнгө оруулагч талыг нь дараах баталгаагаар хангана:

19.3.1.энэ хуулийн 19.2-т заасан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, цуцлах асуудлыг шийдвэрлэхдээ Захиргааны ерөнхий хуульд заасан журам, үндэслэлийг баримтлах;

19.3.2.хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллээр хангагдах;

19.3.3.хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол газар эзэмшүүлж, ашиглуулах шийдвэрээ өөрчлөхгүй байх;

19.3.4.тусгай зөвшөөрөл олгох;

19.3.5.эрх бүхий албан тушаалтан, нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, эдэлбэр газрын бүсчлэл өөрчлөгдөхөөс үл хамаарч гэрээний тогтвортой байдлыг хангах;

19.3.6.ажиллах цагийн хуваарийг уян хатан шийдвэрлэх;

19.3.7.гэрээ байгуулах үед нийслэлээс тогтоосон албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй байх;

19.3.8.нийтийн ашиг сонирхлын үүднээс хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, зорилгоос хамаарч холбогдох журамд заасан зардлын санхүүжүүлтийг тогтмол олгох;

19.3.9.хуульд заасан бусад.

19.4.Энэ зүйлд заасан хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

19.5.Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээртэй хамтран ажиллаж нийслэл хотыг хөгжүүлэх зорилгоор Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн дэргэд байгуулж болно.

19.6.Энэ хуулийн 19.5-д заасан Зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч батална.

## **20 дугаар зүйл. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх төрийн өмч**

20.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт улсын хөрөнгө оруулалтаар үл хөдлөх хөрөнгө барих тохиолдолд нийслэл хотын удирдлагын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

20.2.Нийслэлийн нутаг дэвсгэр дэх төрийн өмч, улсын чанартай замын арчилгаа, засвар үйлчилгээг гэрээний үндсэн нийслэл хотоор гүйцэтгүүлж болно.

## **21 дүгээр зүйл. Нийслэлийн чөлөөт бүс**

21.1.Нийслэл нь чөлөөт бүстэй байна.

21.2.Нийслэлийн чөлөөт бүсийг түүний нутаг дэвсгэр, дагуул хотын эдэлбэр газарт байгуулж болно.

21.3. Нийслэлийн чөлөөт бүстэй холбоотой харилцааг хуулиар нарийвчлан зохицуулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийслэл хотын удирдлага, түүний бүрэн эрх

#### 22 дугаар зүйл. Нийслэл хотын удирдлага, түүний онцлог

22.1. Нийслэл хотын удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хуульд заасан ёсоор бүрдэнэ.

22.2. Нийслэл хот дараах удирдлагатай байна:

22.2.1. нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

22.2.2. нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч.

22.3. Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагч байх бөгөөд нийслэл хотын тусгай болон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх, хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах, мэргэжлийн албадыг зохицуулан удирдах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулна.

22.4. Хотын ерөнхий менежер нь Улаанбаатар хотын Захирагчийн удирдлага дор ажиллана.

#### 23 дугаар зүйл. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

23.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1. энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасан чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

23.1.2. энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжилтийн талаарх нийслэлийн Засаг даргын тайланг сонсох;

23.1.3. нийслэлийн чиг үүрэг хэрэгжүүлэх талаар нийтлэг болон тусгайлсан журам, стандарт, дүрэм, заавар батлах;

23.1.4. нийслэл хотын болон нийтийн эдэлбэр газар, түүний хэмжээ, ашиглалтын журмыг тогтоох;

23.1.5. хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл, үйлчилгээний төрөл, хэлбэр, түүнийг үзүүлэхэд зарцуулах зардал зэргийг харгалzan татвар, төлбөр, хураамж, урамшууллын хэмжээг тогтоох;

23.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

23.2.Хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхээр баталсан захиргааны хэм хэмжээ агуулсан журам, стандарт, дүрэм, зааврыг холбогдох хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

#### **24 дүгээр зүйл. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бүрэн эрх**

24.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасан нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг Засгийн газрын өмнө хариуцаж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

24.1.2.энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан асуудлаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий санаалыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан хэлэлцүүлэх;

24.1.3.энэ зүйлийн 24.1.2-т заасан асуудлаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;

24.1.4.хуульд заасан нийслэлийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Засгийн газарт асуудал санаачлан оруулах, санал өгөх;

24.1.5.нийслэл хотыг хөгжүүлэх асуудлаар төсөл санаачлах, төсөлд санал, дүгнэлт өгөх, түүнийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүсэх;

24.1.6.хуульд өөрөөр заагаагүй бол нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулснаар дагуул хот, хаяа тосгоны Захирагчийг томилох, чөлөөлөх;

24.1.7.хуульд заасан тохиолдолд нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоож, мөрдүүлэх;

24.1.8.дотоод, гадаадад нийслэлийг төлөөлөх;

24.1.9.зөвлөх эрх бүхий мэргэжлийн орон тооны бус зөвлөл байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

24.1.10.хууль тогтоомжид заасны дагуу нийслэл Улаанбаатар хотыг төлөөлөх этгээдийг томилох, чөлөөлөх;

24.1.11.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх;

24.1.12.Улаанбаатар хотын Ерөнхий менежерт хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх бүрэн эрхээ шилжүүлэх;

24.1.13.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**25 дугаар зүйл. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрхийн баталгаа**

25.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч захирамж гаргана.

25.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны зардлыг улс, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

25.3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил баталгаагаар хангагдана.

**26 дугаар зүйл.Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн бүрэн эрх**

26.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.7, 24.1.9-24.1.19, 24.1.21, 24.1.22, энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-11.1.5, 11.1.7, 11.1.9-11.1.14-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой бүрэн эрхээ Улаанбаатар хотын Ерөнхий менежерт шилжүүлж болно.

26.2.Энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу бүрэн эрхээ шилжүүлсэн нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

26.3.Энэ зүйлийн 26.1-д заасны дагуу бүрэн эрхээ шилжүүлэхдээ түүний хүрээ, хязгаарлалтыг тодорхойлж, тайлагнах, хяналт тавих журмыг гэрээнд тодорхой заана.

26.4.Улаанбаатар хотын Ерөнхий менежер энэ хуульд заасны дагуу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас шилжүүлсэн бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхтэй байна:

26.4.1.Улаанбаатар хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах ажлыг зохион байгуулах;

26.4.2.Улаанбаатар хотын амьдралын хүрээний асуудал хариуцсан байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, удирдах;

26.4.3.Улаанбаатар хотын амьдралын хүрээний асуудлыг шийдвэрлэх зорилгоор иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах;

26.4.4.Улаанбаатар хоттой холбоотой дүүргийн удирдлагын гүйцэтгэж байгаа ажилд хяналт тавих, үүрэг өгөх;

26.4.5.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ажилтныг томилж, чөлөөлөх;

26.4.6.хуульд заасан бусад.

26.5. Улаанбаатар хотын Ерөнхий менежер нь энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд дүүргийн Засаг даргатай шууд харилцах ба дүүргийн Засаг дарга, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр Улаанбаатар хотын ерөнхий менежерийн өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх үүрэгтэй.

26.6. Улаанбаатар хотын Ерөнхий менежер, дүүргийн Засаг даргын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч шийдвэрлэнэ.

26.7. Улаанбаатар хотын Ерөнхий менежер нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргах бөгөөд тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

## **27 дугаар зүйл.Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба**

27.1. Улаанбаатар хотын Захирагч нь Ажлын албатай байх бөгөөд дэргэдээ хотын амьдралын хүрээний асуудал хариуцсан бие даасан агентлаг /цаашид "агентлаг" гэх/, харьяа газартай байна.

27.2. Энэ зүйлийн 27.1-д заасан агентлаг, харьяа газар байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

27.3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, агентлаг, харьяа газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч тогтооно.

27.4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байна. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дарга нь хотын Ерөнхий менежер байна.

27.5. Захирагчийн ажлын алба нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.5.1. Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;

27.5.2. Улаанбаатар хотын Захирагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

27.5.3. Улаанбаатар хотын амьдралын асуудлыг судлах, нийслэл хотын удирдлагын бодлого, шийдвэрийн төслийг боловсруулах, гарсан шийдвэр, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;

27.5.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хот, нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, бусад байгууллагатай хамтран ажиллах, хяналт тавих;

27.5.5. Энэ хуулийн 10, 11 дүгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийслэл хотын удирдлагад туслах, хамтран ажиллах

27.5.6. хуульд заасан бусад үйл ажиллагааг зохион байгуулах.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **Нийслэл хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах**

**28 дугаар зүйл. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засгийн газар, яам агентлагтай харилцах**

28.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газар, яам, агентлагтай харилцана.

### **29 дүгээр зүйл. Засгийн газартай харилцах**

29.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Засгийн газартай дараах журмаар харилцана:

29.1.1. Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах;

29.1.2. нийслэлийн болон нийслэл хотын чиг үүрэгтэй холбоотой асуудлаар Засгийн газрын хуралдаанд оролцох, байр сууриа илэрхийлэх, асуудал санаачлан оруулах, санал өгөх, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдтэй шууд харилцах;

29.1.3. төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан аливаа шийдвэрийг нийслэлийн эрх ашигт харш хэмээн үзвэл уг шийдвэрийн талаархи санал, дүгнэлтээ Засгийн газарт гаргах.

### **30 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах**

30.1. Төрийн захиргааны төв байгууллага нь салбарын болон салбар хоорондын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхдээ нийслэл хот, түүний оршин суугчийн нийтлэг эрх ашигтай холбогдох асуудлаар нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай зөвшилцэнэ.

30.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь нийслэл хотын эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагатай хамтарсан шийдвэр гаргаж, биелэлтийг зохион байгуулна.

30.3. Нийслэл хот энэ хуульд заасан тусгай чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны төв байгууллага нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

30.4. Төрийн захиргааны төв байгууллагаас өөрийн болон нийслэлд орших харьяа байгууллагынхаа хэрэгцээнд нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмших, ашиглах тухай асуудлыг нийслэлийн удирдлагад тавьж шийдвэрлүүлнэ.

30.5. Холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн захиргааны төв байгууллага нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэр гаргахдаа нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэх үүрэгтэй бөгөөд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн саналыг авсан байна.

### **31 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хоттой харилцах**

31.1.Нийслэлийн удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хотын удирдлагатай нийслэл хотын эдийн засаг, нийгмийн асуудлаар хамтран ажиллаж болно.

31.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хотын удирдлага нь нийслэл хотын хүн амыг бараа, үйлчилгээгээр хангах, нийслэлд үндэсний их баяр наадам, төрийн ёслол хүндэтгэл, улсын болон олон улсын арга хэмжээ зохион явуулахад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дагуу дэмжлэг үзүүлж, үүрэг хүлээнэ.

31.3.Нийслэлийн хөгжилд зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн нэгдсэн сүлжээ, бүтэц бий болгох үйлдвэр, аж ахуй, хангамжийн байгууллагыг Засгийн газрын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн нутаг дэвсгэр дээр байгуулж болно. Энэ тохиолдолд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид татвар төлөх, газар эзэмших, ажлын байраар хангах асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

### **32 дугаар зүйл.Дүүргийн удирдлагатай харилцах, хамтран ажиллах**

32.1.Нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой нийслэл хотын удирдлагын үйл ажиллагаанд дүүргийн удирдлага туслалцаа үзүүлж, үүрэг хүлээнэ.

32.2.Дүүрэг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүний нөөц, техник, эдийн засгийн туслалцаа нийслэл хотын удирдлагаас хүсэж болно.

32.3.Дүүрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах өмчийг нийслэлээс шилжүүлж болно.

32.4.Нийслэл хотын амьдралын асуудлаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Захирагчийн ажлын алба, дүүргийн Засаг дарга үйл ажиллагаагаа уялдуулах үүрэгтэй.

32.5.Нийслэл хотын удирдлага нь дүүргийн эрх ашигтай холбогдох шийдвэр гаргахдаа дүүргийн удирдлагын саналыг авсан байна.

32.6.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг хүн амын тоо, үйлчилгээний хүртээмж зэргийг харгалzan тогтоох тухай саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

### **33 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах**

33.1.Нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор нийслэл хотыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох бөгөөд энэ харилцааг зохицуулах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

33.2. Энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасан нийслэл хотын зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.

### **34 дүгээр зүйл. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс нийслэл хотын өмнө хүлээх үүрэг**

34.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь өмчийн хэлбэрээс үл хамааран нийслэлийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:

34.1.1. нийслэлийн хотын удирдлагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг ажиллагсаддаа мэдээлж, хэрэгжүүлэх;

34.1.2. нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх талаар нийслэлийн удирдлагаас явуулж байгаа үйл ажиллагаанд хуульд заасан хүрээнд дэмжлэг үзүүлэх;

34.1.3. нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын нэгдсэн стандарт мөрдөх, нийслэл хотын удирдлагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх.

### **35 дугаар зүйл. Нийслэл хотын оршин суугч, түүний эрх, үүрэг**

35.1. Нийслэл хотод хууль ёсоор, байнга амьдарч байгаа Монгол Улсын иргэнийг нийслэл хотын оршин суугч гэнэ.

35.2. Нийслэл хотын оршин суугч нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрх, эрх чөлөө, бусад хууль тогтоомжид заасан эрхээс гадна дараахь эрхийг эдэлнэ:

35.2.1. нийслэлийн хотын удирдлагын шийдвэрийн талаар мэдээлэл авах, санал өгөх;

35.2.2. нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдэлбэр газрын бүсчлэлийн дүрэм боловсруулахад санал өгөх, хэрэгжүүлэхэд оролцох;

35.2.3. нийслэл хотын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал гаргах, хувь нэмэр оруулах;

35.2.4. холбогдох стандартын дагуу мод бут тарих, батлагдсан журмын дагуу урамшуулал авах;

35.2.5. нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэлд заасан суурьшлын бүсэд оршин суугаа бол дэд бүтцийн үйлчилгээгээр хангагдах;

35.2.6. хууль тогтоомжид заасан бусад эрх.

35.3. Нийслэл хотын оршин суугч нь нийгэм, эдийн засгийн давуу талыг эдэлж, ажиллаж амьдрах таатай нөхцөлөөр хангагдаж байдгийн хувьд дараахь үүрэг хүлээнэ:

35.3.1.нийслэл хотын удирдлагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг биелүүлэх;

35.3.2.нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлын бүсэд оршин суух;

35.3.3.хотын соёл, харилцааны хэм хэмжээг хүндэтгэн сахих;

35.3.4.нийтийн эзэмшлийн эд зүйлийг зохистой ашиглах, амьдарч, үйл ажиллагаа явуулж байгаа орчноо цэвэр байлгах;

35.3.5.нийслэл хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэлийн дүрмийн дагуу өөрийн орон байр, орчноо тохижуулах;

35.3.6.нийслэл хотын татвар, энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-д заасан төлбөр, хураамж төлөх;

35.3.7.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

35.4.Нийслэл хотын оршин суугч биш Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийслэл хотод амьдарч байх хугацаандаа энэ хууль , бусад хууль тогтоомж, нийслэл хотын удирдлагаас гаргасан шийдвэрийг сахин биелүүлэх үүрэгтэй.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

### **Нийслэл хотын дагуул хот, хаяа тосгон**

#### **36 дугаар зүйл.Нийслэл хотын дагуул хот, түүний зохион байгуулалтын үндэс**

36.1.Нийслэл хотын дагуул хот /цаашид “дагуул хот” гэх/ нь нийслэлтэй эдэлбэр газар, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр, логистикийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, газар зүйн байрлал болон нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдолтой, хот бүрдүүлэгч дэд бүтэц бүхий төвлөрсөн суурин газар мөн.

36.2.Дагуул хот эдэлбэр газартай байна. Дагуул хотын эдэлбэр газрыг улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны эдэлбэр газартай давхардуулан олгож үл болно.

36.3.Дагуул хотын эдэлбэр газар нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдож, Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал баталсан гортиг бүхий байна.

36.4.Дагуул хотын эдэлбэр газрын төлбөрийг тухайн дагуул хотын оршин байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хууль тогтоомжид заасан журмын дагуу төлнө.

36.5.Дагуул хот нь дүрэмтэй байна. Хуулиар зохицуулснаас бусад дагуул хоттой холбоотой асуудлыг дүрмээр зохицуулах ба дагуул хотын дүрмийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

### **37 дугаар зүйл.Дагуул хотыг байгуулах**

37.1.Дагуул хотыг дараах нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал байгуулна.

37.1.1.улсын болон нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр нөлөө;

37.1.2.аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийн ач холбогдол;

37.1.3.үндэсний болон олон улсын тээвэр, логистик болох газар зүйн байрлал;

37.1.4.олон улсын харилцаа, худалдаа, үйлдвэрлэлийн сүлжээ болох дэд бүтэц;

37.1.5.хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахад үзүүлэх нөлөө;

37.1.6.шинжлэх ухаан, инноваци, сургалт, үйлдвэрлэлийн төвийг төрөлжүүлэн хотхон хэлбэрээр хөгжүүлэх боломж.

37.2.Дагуул хотыг байгуулах шийдвэрт түүний оноосон нэр, эдэлбэр газрын хэмжээ, газар зүйн байршлыг тусгана.

### **38 дугаар зүйл. Дагуул хотын чиг үүрэг**

38.1.Дагуул хотын чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

38.1.1.нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт;

38.1.2.унд, ахуйн хэрэгцээний ус хангамж;

38.1.3.авто зогсоолын төлөвлөлт, арчлалт, хамгаалалт;

38.1.4.хөшөө дурсгалын арчлалт, хамгаалалт;

38.1.5.хот тохижилт, олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт;

38.1.6.орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ;

38.1.7.хотын зам, гудамж, талбайн гэрэлтүүлгийн засвар, арчлалт;

38.1.8.хотын доторх зам, замын байгууламж түүний арчилгаа, тэмдэг тэмдэглэгээ арчлалт, хамгаалалт;

38.1.9.хууль тогтоомжид заасан бусад.

### **39 дүгээр зүйл. Дагуул хотын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа явуулах баталгаа**

39.1.Дагуул хотын удирдлага нь захирагч, түүнд зөвлөх үүрэг бүхий зөвлөлөөс бүрдэнэ.

39.2.Дагуул хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж зохион байгуулах үүргийг Захирагч гүйцэтгэнэ. Дагуул хотын Захирагчийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

39.3. Энэ зүйлийн 39.1-т заасан Захирагчийн дэргэдэх Зөвлөлийг тухайн хотын нийгэм, эдийн засагт нөлөө бүхий аж ахуйн нэгж, байгууллага болон оршин суугчдын төлөөллийг оролцуулан 5-11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Захирагч байгуулж, ажиллах журмыг батална.

39.4. Дагуул хотын Захирагч нь Ажлын албатай байна. Дагуул хотын Захирагчийн Ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.

39.5. Дагуул хотын Захирагчийн Ажлын албаны төсвийг нийслэлийн төсөвт тусгайлан батална.

39.5. Энэ хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд дагуул хотын Захирагч захирамж гаргах ба тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна.

#### **40 дүгээр зүйл. Нийслэл хотын хаяа тосгон**

40.1. Нийслэл хотын хаяа тосгон /цаашид “хаяа тосгон” гэх/ нь нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдааны зэрэг салбар хөгжсөн суурин газар мөн.

40.2. Хаяа тосгон байгуулах, татан буулгах асуудлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Засгийн газар шийдвэрлэнэ.

40.3. Хаяа тосгон Захирагчтай байна. Хаяа тосгоны Захирагч нь тухайн хорооны Засаг дарга байна.

40.4. Хаяа тосгоны Захирагчийн Ажлын алба нь төсөвтэй байх ба тухайн төсөв нь дүүргийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

#### **41 дүгээр зүйл. Хаяа тосгоны чиг үүрэг**

41.1. Хаяа тосгон нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан хорооны чиг үүргээс гадна дүүргээс шилжүүлсэн дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

41.1.1. тосгон дахь авто зогсоолын арчилгаа;

41.1.2. нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалт;

41.1.3. тосгоны гэрэлтүүлэг, арчлалт;

41.1.4. ахуйн хог хаягдлын тээвэрлэлт;

41.1.5. хуульд заасан бусад.

#### **ДОЛООДУГААР БҮЛЭГ Бусад**

#### **42 дугаар зүйл. Нийслэл хотын гадаад хамтын ажиллагаа**

42.1. Нийслэл хотын удирдлага нь чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор гадаад улсын нийслэл хот болон бусад хот, эсхүл олон улсын байгууллагатай хууль тогтоомжид заасан хүрээнд дараах хэлбэрээр харилцан ашигтай хамтран ажиллана:

- 42.1.1.хамтын ажиллагааны гэрээ байгуулах;
- 42.1.2.олон улсын хотуудын холбоог үүсгэн байгуулах, гишүүнээр элсэх;
- 42.1.3.нийслэл хотын суурин төлөөлөгч харилцан солилцох;
- 42.1.4.хуульд заасан бусад.

42.2. Нийслэл хот нь энэ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу хамтран ажиллахаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.

#### **43 дугаар зүйл. Нийслэл хотын өдөр**

43.1. Нийслэл хотын өдрийг жил бүр тэмдэглэнэ. Нийслэл хотын өдрийг Улсын Их Хурал тогтооно.

#### **44 дүгээр зүйл. Нийслэл хотын шагнал**

44.1. Нийслэл хотыг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан иргэнийг "Нийслэл хотын хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнана. "Нийслэл хотын хүндэт иргэн"-д өргөмжлөх асуудлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчын өргөн мэдүүлснээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

44.2. "Нийслэл хотын хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

#### **45 дугаар зүйл. Нийслэл хотын судалгааны байгууллага**

45.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч дэргэдээ хотын хөгжлийн түүх, хэтийн төлөвийг тодорхойлох, хотжилт, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны асуудал болон олон нийтийн санаа бодлыг судлах судалгаа, шинжилгээний төвтэй байж болно.

45.2. Судалгаа, шинжилгээний төвийн үйл ажиллагааг Нийслэл хотын хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.

#### **46 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

46.1. Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1994 оны 7 дугаар сарын 5-ны өдөр баталсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 20 оны .. дугаар сарын ..-ны өдөр баталсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,” гэсний дараа “Нийслэл хотын эрх зүйн байдлын тухай хууль” гэж, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйл” гэсний дараа “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Төсвийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 56 дугаар зүйлийн 56.2 хэсэг:

56.2.Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгийн 70 хувийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.

**3 дугаар зүйл.** Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д “татварын бус орлогын” гэснийг “торгуулийн орлого, төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогын” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1, 56.2.2, 58 дугаар зүйлийн 58.1.4, 58.1.5, 58.1.7, 58.1.19 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20 . оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Өрийн удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

#### 1/ 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалт:

“4.1.24.“нийслэлийн үнэт цаас” гэж нийслэлээс энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, зориулалт, журмын дагуу дотоод, гадаадын зах зээлд арилжаалсан өрийн бичгийг.”

#### 2/ 28<sup>1</sup> дүгээр зүйл:

##### “28<sup>1</sup> дүгээр зүйл. Нийслэлийн үнэт цаас гаргах

28<sup>1</sup>.1.Нийслэл нь хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргаж болно.

28<sup>1</sup>.2.Энэ хуулийн 28<sup>1</sup>.1-д заасан хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлах бөгөөд тухайн төсөл, хөтөлбөр нь дараахь шаардлагыг хангасан байна:

28<sup>1</sup>.2.1.шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ нь 30.0 тэрбум төгрөгөөс доошгүй байх;

28<sup>1</sup>.2.2.төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх;

28<sup>1</sup>.2.3.эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, эсхүл олон улсын болон Европын холбооны стандартын шаардлагад нийцсэн экспортын болон импортыг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн байх.

28<sup>1</sup>.3.Нийслэлийн Засаг дарга нь нийслэлийн үнэт цаас гаргагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд нийслэлийн үнэт цаас гаргах саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

28<sup>1</sup>.4.Нийслэлийн үнэт цаас гаргахад энэ хуулийн 19.1-д заасныг удирдлага болгох бөгөөд дараахь шаардлагыг хангасан байна:

28<sup>1</sup>.4.1.Засгийн газраас үнэт цаас гаргах тухай зөвшөөрөл авсан байх;

28<sup>1</sup>.4.2. Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээнд нийцсэн байх;

28<sup>1</sup>.4.3. иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийслэлийн үнэт цаас гаргах санаачилгыг дэмжсэн байх.

28<sup>1</sup>.5. Нийслэлийн үнэт цаас гаргах шийдвэрийн төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нийслэлийн Засаг дарга хамтран Засгийн газарт оруулах бөгөөд Засгийн газар нийслэлийн үнэт цаас гаргах эсэхийг шийдвэрлэнэ.

28<sup>1</sup>.6. Энэ хуулийн 28<sup>1</sup>.5-д заасан Засгийн газрын зөвшөөрөлд үндэслэн аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах шийдвэрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батална.

28<sup>1</sup>.7. Нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбоотой журмыг Засгийн газар батална.

28<sup>1</sup>.8. Нийслэлийн үнэт цаас гаргахтай холбогдсон зардлыг тухайн жилийн нийслэлийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

28<sup>1</sup>.9. Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчиж нийслэлийн үнэт цаас гаргахыг хориглоно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 15.33 дугаар зүйл нэмсүгэй:

#### “15.33 дугаар зүйл. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих

1. Нийтийн эзэмшлийн эд зүйлийг эвдсэн, сүйтгэсэн, дур мэдэн ашигласан тохиолдолд хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Төлөвлөлтгүй газар суурьшсан болон суурьшил үүсгэсэн бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, албадан нүүлгэнэ.

3. Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний акт, нийслэл хотын дүрмийг зөрчсөн, дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Өөрийн эзэмшиж байгаа эдэлбэр газар, барилга, байгууламжаасаа 50 метр хүртэлх зайнд байгаа гудамж, талбайг стандарт, норм, дүрэм, журам, зохих шаардлагын дагуу зүй зохистой ашиглах үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн бол иргэнийг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ногоон байгууламжийг сүйтгэсэн бол хугалсан, устгасан мод, бут, сөөгийг ширхэгээр, сүйтгэсэн цэцэг, зүлгийн эзлэх талбайн хэмжээг 5 дахин ёсгөсөн хэмжээгээр нөхөн сэргээлгүүлж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай 24<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

**“24<sup>1</sup> дүгээр зүйл. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бүрэн эрх**

24<sup>1</sup>.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч дараахь бүрэн эрхтэй:

1/нийслэлийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой нийгэм, здийн засгийн хөгжлийн болон шаардлагатай бусад тулгамдсан асуудлын хүрээнд санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулах, шийдвэрлүүлэх;

2/энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3, 5-7 дахь заалтад заасан.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ